
**Мэдээллийн технологи- МТ-ийн
засаглал — МТ-ийн технологийн
засаглалын үнэлгээ**

Агуулга	
Өмнөх үг.....	4
Танилцуулга.....	5
1 Хамрах хүрээ.....	6
2 Норматив эшлэл.....	6
3 Нэр томьёо, тодорхойлолт.....	6
3.1 Өгөөжтэй үр дүн.....	6
3.2 Амжилтын нотолгоо.....	6
4 Мэдээллийн технологийн засаглалын үнэлгээний үр өгөөж.....	7
4.1 Орчин нөхцөл.....	7
4.2 МТ-ийн засаглалын үнэлгээний үр өгөөж.....	7
5 Үнэлгээний хамрах хүрээ, арга.....	8
5.1 Хамрах хүрээг тогтоох.....	8
5.2 Үнэлгээний арга, оролцогч талууд.....	10
5.3 Үүрэг, хариуцлага, ур чадвар.....	11
5.3.1 МТ-ийн засаглалын үнэлгээтэй холбоотой үүрэг.....	11
5.3.2. Эрх бүхий субъект.....	11
5.3.3 Санжүүжүүлэгч (sponsor).....	12
5.3.4 Гүйцэтгэх удирдлага.....	12
5.3.5 Үнэлгээний эксперт (үнэлгээний ажилтан).....	13
5.3.6 Бизнесийн шинжээч.....	13
5.3.7 Техникийн шинжээч.....	14
6 МТ-ийн засаглалын үнэлгээ.....	14
6.1 Үнэлгээний тойм.....	14
6.2 МТ-ийн засаглалын жишиг загвар.....	15
6.2.1 МТ-ийн практик чиглэлүүдийн засаглал.....	15
6.2.2 МТ-ийн үзүүлэлтүүдийн засаглал.....	16
6.2.3 МТ-ийн засаглалын хэмжилтийн загвар.....	16
6.2.4 Мэдээллийн технологийн засаглалын үнэлгээний бүтэц.....	17
6.3 МТ-ийн засаглалын үнэлгээ.....	18
5-р зураг – МТ-ийн засаглалын үнэлгээний график дүрслэлийн жишээ.....	19
6.4 МТ-ийн төлөвшлийн загварын засаглал.....	19
7 Үнэлгээний үйл ажиллагаа.....	21
7.1 Үнэлгээг төлөвлөх.....	21
7.2 Үнэлгээг хийх.....	22
7.2.1 Мэдээлэл цуглуулах.....	22
7.2.2 Үнэлгээ хийх.....	22

7.3 Үнэлгээг тайлагнах	23
А хавсралт	24
(Мэдээллийн)	24
Үнэлгээний бүтэц — МТ-ийн үйл ажиллагааны чиглэлийн засаглал.....	24

Өмнөх үг

ОУСБ (Олон улсын стандартчиллын байгууллага) ба ОУЦТК (Олон улсын цахилгаан техникийн комисс) нь дэлхий даяар стандартчиллын мэргэшсэн тогтолцоог бүрдүүлж байна. ОУСБ болон ОУЦТК-ийн гишүүн үндэсний байгууллагууд нь техникийн үйл ажиллагааны тодорхой салбарыг шийдвэрлэхээр холбогдох байгууллагаас тодорхой чиглэлийн дагуу байгуулсан техникийн хороодоор дамжуулан олон улсын стандартыг боловсруулахад оролцдог. ОУСБ болон ОУЦТК-ийн техникийн хороод сонирхсон чиглэлээр хамтран ажилладаг. ОУСБ болон ОУЦТК-тай хамтран ажилладаг төрийн болон төрийн бус бусад олон улсын байгууллагууд уг ажилд оролцдог.

Энэ баримт бичгийг боловсруулахад ашигласан болон цаашид дахин сайжруулах, хянах журмыг ОУСБ/ОУЦТК-ийн Удирдамжийн 1-р хэсэгт тайлбарласан болно. Тухайн баримт бичгийн төрлөөс хамааран, өөр өөр шалгуурыг шаарддаг болохыг тэмдэглэвэл зохино. Энэ баримт бичгийн төслийг ОУСБ/ОУЦТК Удирдамжийн 2-р хэсэгт дурдсан хянах засвар оруулах журмын дагуу боловсруулсан (www.iso.org/directives -ыг үзнэ үү).

Энэ баримт бичгийн зарим бүрдэл хэсэг нь патентын эрхэд хамаарч болзошгүйд анхаарал хандуулсан. ISO болон IEC нь патентын эрхийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн тодорхойлох талаар аливаа хариуцлага хүлээхгүй. Баримт бичгийг боловсруулах явцад илэрсэн аливаа патентын эрхийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл нь Танилцуулга хэсэг болон/эсвэл ОУСБ-ын хүлээн авсан патентын мэдүүлгийн жагсаалт (www.iso.org/patents) -д байна.

Баримт бичгийг боловсруулах явцад тодорхойлсон аливаа патентын эрхийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулга ба/эсвэл хүлээн авсан патентын мэдүүлгийн ISO жагсаалтад оруулна (www.iso.org/patents-ыг үзнэ үү).

Энэхүү баримт бичигт ашигласан аливаа худалдааны нэр нь хэрэглэгчид тохиромжтой байх зорилгоор оруулсан мэдээлэл бөгөөд мөрдүүлэх зорилгогүй.

Стандартын зөвлөмжийн мөн чанарыг тайлбарлахын тулд тохирлын үнэлгээнд хамаарах ОУСБ-ын онцлог нэр томъёо ба хэллэг болон Дэлхийн худалдааны байгууллагын Худалдаан дахь саад тотгорыг бууруулах тухай хэлэлцээрийн зарчмыг дагаж мөрдөхтэй холбоотой мэдээллийг дараах сайтаас үзнэ үү: www.iso.org/iso/foreword.html -ыг үзнэ үү.

Энэ стандартыг Мэдээллийн технологийн үйлчилгээний менежмент ба мэдээллийн технологийн засаглалын 40-р Хамтарсан дэд хороо (ISO/IEC JTC 1/SC 40)-оос боловсруулсан.

Энэхүү баримт бичгийн талаархи санал хүсэлт, асуултыг үндэсний стандартын байгууллага (Стандарт, хэмжил зүйн газар)-т илгээвэл зохино. Эдгээр байгууллагуудын бүрэн жагсаалтыг www.iso.org/members.html болон www.iec.ch/national-committees вэбсайтаас олж болно.

Энэ стандартыг Олон улсын цахилгаан техникийн комиссын Хөгжиж буй оронд зориулсан хөтөлбөрийн удирдагч Г.Батцэнгэл холбогдох хууль тогтоомж, стандартын нэр томъёонд нийцүүлэн орчуулж, Монгол Банкны Мэдээллийн технологийн аудитор М.Саруул хянасан.

Танилцуулга

Эрх бүхий субъектууд нь байгууллагын өмнө хүлээсэн хариуцлагын нэг хэсэг болох мэдээллийн технологийн (мэдээллийн технологи) одоогийн болон ирээдүйн ашиглалтыг байгууллагын хүрээнд хариуцаж, үүрэг хүлээдэг. Энэхүү үүргээ биелүүлэхийн тулд эрх бүхий субъектын гишүүд байгууллагад мэдээллийн технологийн ашиглалтын чиглэлийг тодорхойлоход оролцоогоо хангах, түүнчлэн мэдээллийн технологийн менежментийг хянах, үнэлэх зэргээр байгууллагад мэдээллийн технологийн үр дүнтэй засаглалыг бүрдүүлэхийг зөвлөж байна.

ISO/IEC 38500 стандарт нь байгууллагын МТ-ийг үнэлэх, удирдан чиглүүлэх, хянахад ашиглах эрх бүхий субъектуудын зарчим, нэр томъёо болон загварыг тодорхойлсон. Энэхүү баримт бичигт байгууллагын МТ-ийн засаглалыг ISO/IEC 38500, ISO/IEC TS 38501 болон ISO/IEC TR 38502 стандартад дурдсан зохицуулалтын дагуу үнэлэх арга зүйгээр хангана.

МТ-ийн засаглалын тусгайлсан зохицуулалт нь байгууллага бүрт өөр өөр байдаг. Өөрчлөлт нь байгууллагын стратегийн болон үйл ажиллагааны хувьд мэдээллийн технологиос хамаарах түвшин, байгууллагын хэмжээ, орчин зэрэг янз бүрийн хүчин зүйлээс хамаарна.

Эрх бүхий субъектууд байгууллагын засаглалын талаархи ерөнхий үүрэг хариуцлагын нэг хэсэг болгон МТ-ийн засаглалыг тасралтгүй сайжруулахыг эрэлхийлэх нь зүйтэй, одоогийн зохицуулалтууд нь байгууллагын хэрэгцээнд нийцэж буй эсэхийг үнэлвэл зохино. Тэд эдгээр үнэлгээг МТ-ийн засаглалын үр ашгийг зохион байгуулалт, төлөвлөгөөтэй байдлаар сайжруулахад ашиглавал зохино. Үнэлгээ нь МТ-ийн засаглалыг дэмжих удирдлагын арга барилаас гадна удирдлагын үйл ажиллагааг үнэлэх, удирдан чиглүүлэх, хянах өөрийн арга барилын үр нөлөөнд чиглэвэл зохино.

Энэхүү баримт бичгийн зорилго нь эрх бүхий субъектууд, дэд хороод болон бусад гол оролцогч талуудад байгууллагын МТ-ийн засаглалын зохицуулалтын чадвар, төлөвшлийг үнэлэхэд туслахад оршино.

Энэ нь эрх бүхий субъект МТ-ийг зохих ёсоор удирдаж байгаа эсэхийг тодорхойлох бодитой хандлагыг тогтоож, түүнчлэн МТ-ийн сайн засаглалын туршлага, үр дүнгийн жишээг (энэ баримт бичигт "үзүүлэлт" characteristics' гэж нэрлэсэн) өгнө. (А хавсралт аас А.1-ээс А.7-хүснэгтийг үзнэ үү). Үнэлгээний үр дүн нь эрх бүхий субъект байгууллагын МТ-ийн засаглалыг хаана, хэрхэн сайжруулах боломжтойг тодорхойлоход туслах зорилгоор ашиглаж болно.

Энэхүү баримт бичгийн үндсэн хэрэглэгчид нь эрх бүхий субъект болон түүний дэд хороод, гүйцэтгэх менежерүүд болон үнэлгээний ажилтнууд бөгөөд тэд байгууллагын МТ-ийн засаглалын үнэлгээг төлөвлөхдөө энэхүү баримт бичгийн үр ашгийг хүртэх болно.

Мэдээллийн технологи — МТ-ийн засаглал — МТ-ийн засаглалын үнэлгээ

1 Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь ISO/IEC 38500 болон ISO/IEC TR 38502 стандартад тусгасан мэдээллийн технологийн засаглалын зарчим, нэр томъёо, загварт үндэслэсэн мэдээллийн технологийн (МТ) засаглал болон 38501 стандартад дурдсан хэрэгжилтийг үнэлэх арга зүйгээр хангана.

Энэхүү баримт бичигт үнэлгээ хийх арга барил, үнэлгээний шалгуурууд, үнэлгээнд ашиглах нотолгооны арга зүй, түүнчлэн байгууллагын МТ-ийн засаглалын төлөвшлийг тодорхойлох аргыг агуулсан болно.

Энэхүү баримт бичгийг МТ-ийн ашиглалтын цар хүрээ, хэмжээнээс үл хамааран, бүх байгууллагад хэрэглэнэ.

2 Норматив эшлэл

Дараахь баримт бичгүүдийг бичвэрт дурдсан бөгөөд тэдгээрийн зарим буюу бүх агуулга нь энэхүү баримт бичгийн шаардлагуудад нийцнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэл хамаарна. Он заагаагүй эшлэлийн хувьд эш татсан баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэл (өөрчлөлтийг оруулаад) хамаарна.

ISO/IEC 38500, *Мэдээллийн технологи - Байгууллагын мэдээллийн технологийн удирдлага*

ISO/IEC TS 38501, *Мэдээллийн технологи - Мэдээллийн технологийн засаглал - Хэрэгжүүлэх гарын авлага*

ISO/IEC TR 38502, *Мэдээллийн технологи - Мэдээллийн технологийн засаглал – Тогтолцоо ба загвар*

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү баримт бичгийн зорилгод дараах нэр томъёо, тодорхойлолтуудыг хэрэглэнэ.

ISO болон IEC нь стандартчилалд ашиглах нэр томъёоны мэдээллийн санг дараах хаягаар ажиллуулдаг:

— IEC Electropedia: <https://www.electropedia.org/>

— ISO Онлайн хайлтын платформ: <https://www.iso.org/obp>

3.1 өгөөжтэй үр дүн

мэдээллийн технологийг амжилттай нэвтрүүлж, ашигласнаар байгууллага өндөр түвшний зорилгодоо хүрсэн байдал

3.2 амжилтын нотолгоо

Өгөөжтэй үр дүнд хүрэхийг дэмжиж, боломж бүрдүүлж буй мэдээллийн технологийн ажиллагаа/үйл явцын ажиглагдахуйц, хэмжигдэхүйц үр дүн

4 Мэдээллийн технологийн засаглалын үнэлгээний үр өгөөж

4.1 Орчин нөхцөл

Оролцогч талуудынхаа хүлээлтэд тогтмол нийцсэн, урт хугацааны үнэ цэнийг бий болгохуйц, МТ-ийн ашиглалтын тогтолцоог бий болгож, хадгалахын тулд МТ-ийн засаглал нь эрх бүхий субъект, удирдлага нь зохих зан төлөвийг бий болгоно. Үүнд:

- үйлчилгээ, зах зээл, бизнесийн тасралтгүй шинэчлэл;
- Байгууллагын стратегийн зорилгод хүрэхийн тулд мэдээллийн технологийн эрэлт, нийлүүлэлтэд хүлээх хариуцлага, үүргийн тодорхой байдал;
- Мэдээллийн технологийн оролцоотойгоор бизнесийн тасралтгүй, тогтвортой байдлыг хангаж буй байдал;
- МТ-ийн хөрөнгө оруулалт бүрээс хүлээгдэж буй үр ашгийн хэрэгжилт;
- холбогдох үүргийн биелүүлэлт (зохицуулалт, хууль тогтоомж, нийтлэг эрх зүй, гэрээ);
- МТ-ийн эрсдлийн менежментэд үр дүнтэй хяналт;
- Бизнес ба МТ-ийн удирдлага, гадаад түншүүдтэй бүтээлч, үр дүнтэй харилцаа холбоо.

Байгууллагууд МТ-ийн засаглалын үйл ажиллагаанд хүссэн үр дүндээ хүрэхэд нь олон төрлийн саад тотгор тулгардаг бөгөөд, үүнд:

- Эрх бүхий субъект болон гүйцэтгэх менежерүүд МТ-ийн засаглалын хариуцлагыг технологи хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтнуудад шилжүүлэх;
- МТ-ийн засаглал ба МТ менежментийн хоорондын харилцааг тодорхой болгох бодлого, тогтолцоо дутмаг;
- үр дүнтэй шийдвэр гаргалт, зохистой зан төлөв, хүний зөв харилцаа болон үйлдлээс илүүтэй байгууллагын үйл явцаас хамааралтай байх;
 - зан төлөв, хүлээгдэж буй үр дүнг ажиглаж хянах /monitoring/, хэмжихэд хүндрэлтэй байх, үүнд:
 - МТ-ийн зорилтууд нь байгууллагын зорилго, зорилтуудын нийцлийг хангах;
 - МТ-ийн эрсдэлийг илрүүлж, бууруулах;
 - байгууллагын хөрөнгө, нөөц, тасралтгүй төлөвлөлтийг удирдах;
 - байгууллагын тогтоосон болон хүлээгдэж буй зан төлөвийн хэм хэмжээнд нийцэх;
 - үйлчилгээ болон шийдлийг хүргэхэд мэдээллийн технологийн хариуцлагыг хүлээх;
 - Мэдээлэл, шинэ технологи нэвтрүүлэх замаар бизнесийн загваруудад хувьсал хийх

4.2 МТ-ийн засаглалын үнэлгээний үр өгөөж

Байгууллага МТ-ийн засаглалын зохицуулалт нь хүссэн үр дүнд хүрч, гол үр өгөөжөө өгч байгаа эсэхийг үнэлэх бүтэцлэгдсэн аргачлалыг хэрэгжүүлснээр дараах үр ашгийг хүртэнэ. Үүнд:

- МТ-ийн засаглалын тогтолцоог боловсруулахад туслах;
- МТ-ийн одоогийн засаглалын чадавхийн давуу болон сул талуудыг тодорхойлох;
- сайжруулах шаардлагатай арга хэмжээг тодорхойлоход туслах;
- МТ-ийн засаглалтай холбоотой хүлээлт, үр дүнгийн талаар гүйцэтгэх менежерүүд болон эрх бүхий субъектын харилцааны үвшинг сайжруулах;
- МТ-ийн засаглалын талаар эрх бүхий субъектэд тэдний үүрэг, хариуцлагын талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах;
- МТ-ийн нийцлийг хангахад байгууллагуудад туслах;
- засаглалын оролцогч талууд болон туслах ажилтнуудад эргэх холбоог бий болгох.


5 Үнэлгээний хамрах хүрээ, арга

5.1 Хамрах хүрээг тогтоох

Эрх бүхий субъект үнэлгээний хамрах хүрээ, шаардлага, зорилтыг тодорхойлно. Эрх бүхий субъектнь МТ-ийн засаглалын үнэлгээний үр дүнг шаардаж буй эсвэл үр шимийг нь хүртэх боломжтой оролцогч талуудыг тодорхойлно. Үнэлгээний загварын боловсруулахдаа эдгээр оролцогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг харгалзан үзнэ.

Үнэлгээний хамрах хүрээ, чиглэл, тэргүүлэх чиглэлийг тогтоохдоо хамгийн их үр өгөөжийг бий болгох, нөөцийг дэмий зарцуулахгүйн тулд байгууллагын хамгийн чухал асуудлуудыг үнэлэхэд анхаарна. Үүнд МТ-ийн үйл ажиллагааны хамаарлын түвшин, хангалтын орцууд байгаа эсэх, түүнчлэн байгууллагын чухал, тэргүүлэх ач холбогдол бүхий аливаа тодорхой стратегийн санаачлагыг харгалзан үзнэ.

1-р зурагт үнэлгээний хамрах хүрээг тодорхойлохдоо анхаарвал зохих ISO/IEC TS 38501 стандартад дурдсан МТ-ийн засаглалын хэрэгжилтэд холбоотой талбаруудыг харуулав.



1-р зураг — MT-ийн засаглалын үнэлгээнд анхаарах талбарууд ажиллагаанууд [ЭХ СУРВАЛЖ: ISO/IEC TS 38501:2015, 1-р зураг]

1-р хүснэгтэд үнэлгээний хамрах хүрээг тогтоохдоо анхаарвал зохих ISO/IEC TS 38501-д дурдсан MT-ийн засаглалын хэрэгжилттэй холбоотой гол асуудлуудыг тодорхойлсон.

1-р хүснэгт- Мэдээллийн технологийн засаглалын үнэлгээнд анхаарах гол асуудлууд

Дэмжигч орчныг бүрдүүлж, тогтвортой хадгалах
<ul style="list-style-type: none"> - MT-ийн засаглалын зорилго, зорилтууд - оролцогч талууд, үүрэг, хариуцлагын талаархи ойлголт - оролцогч талуудын оролцоо - эрх мэдлийг шилжүүлэх
MT-ийг засаглах
<ul style="list-style-type: none"> - EDM (Evaluate-Direct-Monitor буюу Үнэл-Удирдан чиглүүл-Мониторинг хий) загварын зургаан зарчмыг хэрэглэх - засаглалыг удирдах бүлэг - дотоод болон гадаад орчин - одоогийн болон хүссэн төлөв байдал, үр өгөөжтэй үр дүнгийн илэрхийлэх - ажиглаж хянах чадвар, амжилтын нотолгоог тодорхойлох - өөрчлөлтийн хөтөлбөр
Байнгын дүн шинжилгээ

- МТ-оос бий болсон үнэ цэнийг сайжруулах
- МТ-тэй холбоотой эрсдлийг удирдах
- засаглалын нэмэлт шаардлагатай арга хэмжээ

5.2 Үнэлгээний арга, оролцогч талууд

Үнэлгээний аргыг бий болгохдоо үнэлгээний зорилго/зорилго, үнэлгээнд шаардагдах бие даасан байдлын зэрэг, үнэлгээний ажилтнууд болон оролцогчдын ур чадвар/мэдлэг, байгууллагын дотор МТ-ийн засаглалын онцлог зохицуулалтаас хамаарах бусад холбогдох хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

Эрх бүхий субъект үнэлгээний аргыг батална. Үнэлгээний хамрах хүрээний дэлгэрэнгүй мэдээлэл, үнэлгээний төлөвлөгөө, үнэлгээний ажилтнуудын үүрэг, хариуцлага, үнэлгээ хийх цаг хугацаа, үнэлгээнд шаардлагатай нөөц, үнэлгээний ажилтнуудын ур чадвар, мэдлэгийн талаарх ойлголтыг агуулсан байна.

МТ-ийн засаглалын үнэлгээний төрөл бүрийн арга байдаг. Үнэлгээний арга, гол анхаарах зүйлсийг 2-р хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

2-р хүснэгт-Үнэлгээний арга, гол анхаарах зүйлс

	Эрх бүхий субъектийн үнэлгээ	Дотоод үнэлгээ	Гадаад үнэлгээ
Тайлбар	Эрх бүхий субъектээс хийж буй МТ-ийн засаглалын үнэлгээ; өөрийн үнэлгээтэй төстэй гэж үзэж болно.	МТ-ийн засаглалын үнэлгээг хүлээн зөвшөөрөгдсөн, чадварлаг, мэдлэгтэй дотоод нөөц эсвэл үнэлгээний ажилтнууд дэмжиж оролцон хийдэг.	МТ-ийн засаглалын үнэлгээг хүлээн зөвшөөрөгдсөн, чадварлаг, мэдлэгтэй гадаад нөөц эсвэл үнэлгээний ажилтнууд дэмжиж оролцон хийдэг.
Зорилго	<ul style="list-style-type: none"> — өндөр түвшний өөрийн үнэлгээ — Эрх бүхий субъект МТ-ийн засаглалын талаар өөрийн гүйцэтгэлийг ажиглаж хянах (monitor) боломжийг олгоно. 	<ul style="list-style-type: none"> — нарийвчилсан дотоод үнэлгээ — МТ-ийн засаглалтай холбоотой үүрэг хариуцлагаа хэр зэрэг биелүүлж байгаа талаар эрх бүхий субъектэд дотоод мэдээллийг өгнө. 	<ul style="list-style-type: none"> — нарийвчилсан хөндлөнгийн гадаад үнэлгээ — МТ-ийн засаглалтай холбоотой үүрэг хариуцлагаа хэр зэрэг биелүүлж байгаа талаар эрх бүхий субъектэд гадаад мэдээллийг өгнө.
Үр өгөөж	<ul style="list-style-type: none"> — хурдан/хялбар — үнэлгээний ажилтнаас хамааралгүй (дотоод болон гадаад) 	<ul style="list-style-type: none"> — илүү өргөн оролцоотой (гүйцэтгэх удирдлага) — мэдээллийг илүү өндөр түвшинд авч үздэг 	<ul style="list-style-type: none"> — илүү объектив шинжтэй — гадны тайлангийн шаардлагыг дэмжих хандлага
Оролцогчид	<ul style="list-style-type: none"> — эрх бүхий субъект 	<ul style="list-style-type: none"> — эрх бүхий субъект — гүйцэтгэх удирдлага — бизнесийн болон техникийн эксперт 	<ul style="list-style-type: none"> — эрх бүхий субъект — гүйцэтгэх удирдлага — бизнесийн болон техникийн эксперт

Үнэлгээний ажилтан	— эрх бүхий субъектийн гишүүн —	— дотоодын үнэлгээний ажилтан/ууд	— хөндлөнгийн үнэлгээний ажилтан/ууд
Амжилтын нотолгоо	— эрх бүхий субъект өөрөө өөртөө дүгнэлт хийж, дүгнэлтийнхээ дагуу ажиллах үүрэгтэй.	— эрх бүхий субъект нь өөрийн үнэлгээг дэмжиж, дүгнэлтийн дагуу ажиллах үүрэгтэй — дотоод нөөц нь эрх бүхий субъектэд үнэлгээ хийхэд шаардлагатай эрх мэдэлтэй — байна	— эрх бүхий субъект нь хөндлөнгийн үнэлгээг дэмжиж, дүгнэлтийн дагуу ажиллах үүрэгтэй

5.3 Үүрэг, хариуцлага, ур чадвар

5.3.1 МТ-ийн засаглалын үнэлгээтэй холбоотой үүрэг

Дараах нь МТ-ийн засаглалын үнэлгээний хүрээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүрэг тус бүрийн дэлгэрэнгүй тайлбарыг дор дурдсан дэд зүйлүүдэд өгсөн болно.

- эрх бүхий субъект (5.3.2-ыг үзнэ үү);
- Санжүүжүүлэгч (5.3.3-ыг үзнэ үү);
- гүйцэтгэх удирдлага (5.3.4-ийг үзнэ үү);
- үнэлгээний ажилтан (үнэлгээч) (5.3.5-ыг үзнэ үү);
- бизнесийн шинжээч (5.3.6-г үзнэ үү);
- техникийн шинжээч (5.3.7-г үзнэ үү).

5.3.2. Эрх бүхий субъект

Эрх бүхий субъект нь үнэлгээнд гол үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь үнэлгээний ерөнхий чиглэлийг өгч, засаглалын ерөнхий зорилтод үнэлгээ үнэ цэнэ нэмэх байдлыг хангана. Эрх бүхий субъект үнэлгээг өөрөө хийх тохиолдолд үүрэг хариуцлага, ур чадвар/мэдлэгийн нэсэлт шаардлага тавина. 3-р хүснэгтэд үзүүлэв.

3-р хүснэгт- Эрх бүхий субъектийн үүрэг хариуцлага, ур чадвар

Үүрэг хариуцлага	Мэдлэг/ур чадвар
------------------	------------------

<ul style="list-style-type: none"> — Ерөнхий: <ul style="list-style-type: none"> — Үнэлгээний гол зорилгыг тодорхойлох; — үнэлгээний хамрах хүрээ, аргыг батлах; — үнэлгээний гол зорилгод хүрэхийн тулд гүйцэтгэх удирдлагад боломж олгох; — Үнэлгээ нь гол зорилгын дагуу хүссэн үр дүнг гаргаж байгаа эсэхийг үнэлэх; — үнэлгээ нь засаглалын ерөнхий зорилтуудад үнэ цэнэ нэмэх байдлыг хангах; Санжүүжүүлэгчийн ирүүлсэн үнэлгээний албан ёсны тайланг батлах/татгалзах. — Эрх бүхий субъектийн үнэлгээ: <ul style="list-style-type: none"> — дээр дурдсан ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээнэ; — Үнэлгээ хийх ур чадварын зөрүүтэй бол ур чадварыг бүрлүүлэхээр холбогдох гишүүдийг томилно; — үнэлгээний үйл ажиллагааны тал тайлан боловсруулахыг удирдах 	<ul style="list-style-type: none"> — Ерөнхий <ul style="list-style-type: none"> — ISO/IEC 38500, ISO/IEC TS 38501, ISO/IEC TR 38502 стандартын үндсэн мэдлэгтэй байвал зохино; — байгууллагын үйл ажиллагааны дотоод болон гадаад нөхцөл байдлыг ойлгодог байх; — Эрх бүхий субъектийн үнэлгээ: <ul style="list-style-type: none"> — Эрх бүхий субъектийн үнэлгээнд үнэлгээний ажилтнаар оролцож буй эрх бүхий субъектийн гишүүд шаардлагатай тохиолдолд уг үнэлгээг явуулахад шаардагдах ур чадвар, мэдлэгтэй байна.
---	--

5.3.3 Санжүүжүүлэгч (sponsor)

Санжүүжүүлэгч нь эрх бүхий субъектийн гишүүн юм. Санжүүжүүлэгч нь үнэлгээний хамрах хүрээг эцэслэн боловсруулах, үнэлгээ хийхэд шаардагдах нөөцийн бэлэн байдлыг хангана. Санжүүжүүлэгчийн хариуцлага, ур чадвар/мэдлэгийн шаардлагыг 4-р хүснэгтэд үзүүлэв.

4-р хүснэгт-Санжүүжүүлэгчийн үүрэг хариуцлага, ур чадвар/мэдлэг

Үүрэг хариуцлага	Мэдлэг/ур чадвар
<ul style="list-style-type: none"> — үнэлгээний төлөвлөгөөг эцэслэн боловсруулж батлах; — Үнэлгээнд шаардагдах нөөцөөр хангах; — Үнэлгээний явцад үнэлгээний ажилтан нь шаардлагатай үед бизнесийн болон техникийн шинжээчтэй холбогдох боломжийг бүрдүүлэх; — эцсийн тайланг хянаж, эрх бүхий субъектэд хүргэх. 	<ul style="list-style-type: none"> — ISO/IEC 38500, ISO/IEC TS 38501, ISO/IEC TR 38502 стандартын үндсэн мэдлэгтэй байвал зохино; — байгууллагын үйл ажиллагааны дотоод болон гадаад нөхцөл байдлыг ойлгодог байх;

5.3.4 Гүйцэтгэх удирдлага

Гүйцэтгэх удирдлага нь үнэлгээний талаар эрх бүхий субъектийн зааврыг мөрдөж, үнэлгээний ажилтныг шаардлагатай үнэлгээний мэдээлэл, дэмжлэгээр хангана. Гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлага, ур чадвар/мэдлэгт тавих шаардлагыг 5-р хүснэгтэд үзүүлэв.

5-р хүснэгт-Гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлага, ур чадвар/мэдлэг

Үүрэг хариуцлага	Мэдлэг/ур чадвар
<ul style="list-style-type: none"> — Үнэлгээний гол зорилгод хүрэхийн төлөө ажиллах; — шаардлагатай тохиолдолд үнэлгээний ажилтны бэлтгэсэн үнэлгээний төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийх; — үнэлгээний ажилтныг шаардлагатай мэдээллээр хангах, бизнесийн болон техникийн экспертүүдтэй харилцах; — үнэлгээний тайлангийн үнэн зөв, бүрэн байдлыг шалгах; — эрх бүхий субъект болон доод оролцогч талуудын хоорондын харилцааг удирдах. 	<ul style="list-style-type: none"> — ISO/IEC 38500, ISO/IEC TS 38501, ISO/IEC TR 38502 стандартын үндсэн мэдлэгтэй байвал зохино; — байгууллагын үйл ажиллагааны дотоод болон гадаад нөхцөл байдлыг ойлгодог байх; — бүх оролцогчдын дунд итгэлцэл, хувийн хариуцлагыг бий болговол зохино;

5.3.5 Үнэлгээний эксперт (үнэлгээний ажилтан)

Үнэлгээний эксперт (үнэлгээний ажилтан) нь бодит үнэлгээг хийдэг хувь хүн эсвэл бүлэг хүмүүс юм. Үнэлгээний ажилтны үүрэг хариуцлага, ур чадвар/мэдлэгийн шаардлагыг 6-р хүснэгтэнд үзүүлэв

6-р хүснэгт-Үнэлгээний ажилтны үүрэг хариуцлага, ур чадвар/мэдлэг

Үүрэг хариуцлага	Мэдлэг/ур чадвар
<ul style="list-style-type: none"> — Үнэлгээний гол зорилгыг ойлгож, баримтжуулах; — үнэлгээний арга батлагдсан эсэхийг шалгах; — Үнэлгээ эхлэхээс өмнө үнэлгээний хамрах хүрээг зохих ёсоор тогтоосон эсэхийг шалгах; — Үнэлгээний төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах; — үнэлгээний тайланг бэлтгэж хүргүүлэх. 	<ul style="list-style-type: none"> — ISO/IEC 38500, ISO/IEC TS 38501, ISO/IEC TR 38502 болон үнэлгээний тогтолцооны талаар сайн мэдлэгтэй байвал зохино; — Байгууллага доторх МТ-ийн засаглалын зохицуулалт, төрөл бүрийн үүрэг, тэдгээрийн хувь нэмрийг ойлгох; — Үнэлгээний стандарт, сайн туршлагын талаар маш сайн мэдлэгтэй байх ба үнэлгээнд ижил байдлаар хэрэгжүүлэхийг дэмжих туршлагатай байх.

5.3.6 Бизнесийн шинжээч

Бизнесийн шинжээч гэдэг нь бодит үнэлгээг хийхэд шаардлагатай бизнесийн мэдээллээр хангадаг дотоод нөөцөд хамаардаг хувь хүн эсвэл бүлэг хүмүүс юм. Бизнесийн шинжээчийн үүрэг хариуцлага, ур чадвар/мэдлэгийн шаардлагыг 7-р хүснэгтэд үзүүлэв.

7-р хүснэгт- Бизнесийн шинжээчийн үүрэг хариуцлага, ур чадвар/мэдлэг

Үүрэг хариуцлага	Мэдлэг/ур чадвар
<ul style="list-style-type: none"> — Үнэлгээний хамрах хүрээ ба зорилгыг ойлгох; — Үнэлгээний явцад шаардлагатай бизнесийн шинжээчийн туршлагаар хангах. 	<ul style="list-style-type: none"> — ISO/IEC 38500, ISO/IEC TS 38501, ISO/IEC TR 38502 стандартын бизнесийн үр өгөөжийн талаар үндсэн мэдлэгтэй байвал зохино;

	<ul style="list-style-type: none"> — байгууллагын бизнесийн үйл явц, дүрэм журмын талаар сайн мэдлэг, ойлголттой байх; — МТ нь бизнесийн инноваци, өөрчлөлт, үнэ цэнийг өсөхөд хэрхэн нөлөөлөхийг ойлговол зохино;
--	--

5.3.7 Техникийн шинжээч

Техникийн шинжээч гэдэг нь бодит үнэлгээг хийхэд шаардлагатай техникийн мэдлэг, дэмжлэгээр хангадаг дотоод нөөцөд хамаардаг хувь хүн эсвэл хэсэг бүлэг хүмүүс юм.

Техникийн шинжээчийн үүрэг хариуцлага, ур чадвар/мэдлэгийн шаардлагыг 8-р хүснэгтэд үзүүлэв.

8-р хүснэгт-Техникийн шинжээчийн үүрэг хариуцлага, ур чадвар/мэдлэг

Үүрэг хариуцлага	Мэдлэг/ур чадвар
<ul style="list-style-type: none"> — Үнэлгээний хамрах хүрээ ба зорилгыг ойлгох; — Үнэлгээний явцад шаардлагатай техникийн туршлагаар хангах. 	<ul style="list-style-type: none"> — ISO/IEC 38500, ISO/IEC TS 38501, ISO/IEC TR 38502 стандартын талаар сайн мэдлэгтэй байвал зохино; — техникийн эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээг ойлгох; — МТ нь бизнесийн инноваци, өөрчлөлт, үнэ цэнийг өсөхөд хэрхэн нөлөөлөхийг ойлгодог байвал зохино; — шинэ технологийн зохицуулалтуудыг ойлгодог байвал зохино;


6 МТ-ийн засаглалын үнэлгээ

6.1 Үнэлгээний тойм

МТ-ийн засаглалын үнэлгээг ISO/IEC 38500, ISO/IEC TS 38501, ISO/IEC TR 38502 зэрэг үндсэн стандартуудад дурдсан МТ-ийн засаглалын жишиг загварыг ашиглан хийнэ. Жишиг загвар нь дараахь дөрвөн бүрдлийг агуулна, тухайлбал:

- МТ-ийн практик чиглэлийн засаглал (6.2.1-ийг үзнэ үү);
- МТ-ийн шалгуурын засаглал (6.2.2-ыг үзнэ үү);
- МТ-ийн засаглалын хэмжилийн загвар (6.2.3-ыг үзнэ үү);
- МТ-ийн засаглалын үнэлгээний хүрээ (6.2.4-ийг үзнэ үү).

2-р зурагт ойлголтуудын хамаарлыг харуулав.



Түлхүүр

- 1 Мэдээллийн технологийн засаглалын үнэлгээ
- X Мэдээллийн технологийн практик чиглэлүүдийн засаглал
- Y үнэлгээ

2-р зураг-МТ-ийн засаглалын үнэлгээний хамаарал

6.2 МТ-ийн засаглалын жишиг загвар

6.2.1 МТ-ийн практик чиглэлүүдийн засаглал

МТ-ийн практик салбаруудын засаглал нь МТ-ийг идэвхитэй засаглахад байгууллагын анхаарлын төвд байдаг гол чиглэлүүд юм. Долоон чиглэлийг тодорхойлсон бөгөөд анх ISO/IEC TS 38501 ба ISO/IEC TR 38502 стандартаас үүссэн. Бусад зургаан практик чиглэл нь ISO/IEC 38500 стандартын зургаан зарчмаас гаралтай:

- Дэмжигч механизмууд;
- Үүрэг;
- Стратеги;
- Худалдан авалт;
- Гүйцэтгэл;
- Нийцэл;
- Хүний зан төлөв.

6.2.2 дэд зүйл болон А.хавсралт нь практик чиглэл тус бүрд тусгагдсан агуулгын талаар нэмэлт мэдээллийг агуулна.

6.2.2 МТ-ийн үзүүлэлтүүдийн засаглал

Үйл ажиллагааны чиглэл бүр үндсэн стандартад тодорхойлсон гурван төрлийн үзүүлэлтүүдийг агуулна, тухайлбал:

- засаглалын үүрэг, үйл ажиллагаа (үнэлэх, удирдлан чиглүүлэх, ажиглан хянах;
- амжилтын нотолгоо (өгөөжтэй үр дүнд хүрсэнийг илтгэх баримтууд);
- өгөөжтэй үр дүн (мэдээлэл технологийн тусламжтайгаар байгууллагын зорилгод хүрэх).

Эдгээр хамаарлыг дараах 3-р зурагт үзүүлэв.

Үйл ажиллагааны талбар (area)		
Үзүүлэлтүүд		
Ангилал: Засаглалын үүрэг ба үйл ажиллагаа (EDM)	Ангилал: Амжилтын нотолгоо	Ангилал: Өгөөжтэй үр дүн
-Үйл ажиллагаа #1	- Амжилтын нотолгоо #1	-Өгөөжтэй үр дүн #1
.....
-Үйл ажиллагаа #n	- Амжилтын нотолгоо #n	-Өгөөжтэй үр дүн #n

3-р зураг-МТ-ийн үзүүлэлтийн засаглалын 3 ангилал бүхий үйл ажиллагаа

МТ-ийн засаглалын тогтолцооны түүвэр үнэлгээний үзүүлэлтүүдийн жишээг үйл ажиллагааны чиглэл, ангиллаар А хавсралтын А.1-аас А.7-д хүснэгтэд үзүүлэв.

Байгууллагууд өөрсдийн байгууллагын нөхцөл байдалд тохируулан үзүүлэлтүүдийг өөрчлөх боломжтой.

6.2.3 МТ-ийн засаглалын хэмжилтийн загвар

ISO/IEC TS 38501 нь хэмжилтийн загварыг зарчимд суурилсан стандартууд нь үр дүнд хүрэх арга хэрэгсэлд биш харин үр дүнд хүрэхэд чиглэдэг тул тоон үзүүлэлтээс илүү чанарын шинжтэй гэж тодорхойлсон. ISO/IEC TS 38501 стандарт дах хэмжилтийн загвар нь үнэлэх, удирдан чиглүүлэх, хянах (EDM) үүрэг, үйл ажиллагааг агуулсан бага зэргийн нэмэлтүүд орж хэвлэгдсэн. Үнэлгээний стандартчилсан шатлал (зүүн гар талын багана) нь хэвээр бөгөөд МТ-ийн үзүүлэлтийг засаглалын гурван ангилал тус бүрээр тодорхой хэмжилээр тодорхойлсон болно. Үүнийг 9-р хүснэгтэд үзүүлэв

9-р хүснэгт - Хэмжилийн үнэлгээний шатлал

Шатлал	Ү-У-Х (EDM) үүрэг ба үйл ажиллагаа	Амжилтын нотолгоо	Өгөөжтэй үр дүн
Мэдэхгүй	Ү-У-Х (EDM) үүрэг ба үйл ажиллагааг гүйцэтгээгүй	Амжилтын нотолгоо байхгүй	Үр дүнд хүрэх тухай мэдлэг ойлголт байхгүй
Хэрэгжээгүй	Ү-У-Х (EDM) үүрэг ба үйл ажиллагаа нь хязгаарлагдмал гүйцэтгэлтэй	Амжилтын нотолгоо бага зэрэг	Ихэнх өгөөжтэй үр дүнд хүрээгүй
Бага хэрэгжсэн	Үнэлэх, удирдан чиглүүлэх зарим үүрэг ба үйл ажиллагааг гүйцэтгэсэн боловч хяналт нь хязгаарлагдмал	Амжилтын зарим нотолгоо харагдах боловч нэг ба түүнээс дээш нотолгоо огт байхгүй	Зарим өгөөжтэй үр дүнд тодорхой хэмжээнд хүрсэн, нэг буюу хэд хэдэн өгөөжтэй үр дүнд огт хүрээгүй.
Нэлээд хэрэгжсэн	Үнэлэх, удирдан чиглүүлэх ихэнх үүрэг ба үйл ажиллагааг зохих түвшинд хяналтын хамт гүйцэтгэсэн	Амжилтын бүх нотолгоо тодорхой харагдах бөгөөд зарим нь бүрэн хэрэгжсэн	Бүх өгөөжтэй үр дүнд нь нэлээд хүрсэн, зарим өгөөжтэй үр дүнд бүрэн хүрсэн
Бүрэн хэрэгжсэн	Ү-У-Х (EDM) үүрэг ба үйл ажиллагаа нь бүрэн гүйцэтгэлтэй	Амжилтын бүх нотолгоо бүрэн хэрэгжиж, үр дүнтэй ажиллаж байна	Бүх өгөөжтэй үр дүнд бүрэн хүрсэн

6.2.4 Мэдээллийн технологийн засаглалын үнэлгээний бүтэц

Үйл ажиллагааны чиглэл бүрийн МТ-ийн үзүүлэлтүүдийн засаглалын ангилал тус бүрт хэмжилтийн загварыг хэрэглэж, МТ-ийн засаглалын үнэлгээний бүтцийг тодорхойлно. Үүнийг 4-р зурагт үзүүлэв.

Үйл ажиллагааны талбар																	
Үзүүлэлтүүд																	
Ангилал: Засаглалын үүрэг ба үйл ажиллагаа (EDM)					Ангилал: Амжилтын нотолгоо					Ангилал: Өгөөжтэй үр дүн							
-Үйл ажиллагаа #1 -Үйл ажиллагаа #n					- Амжилтын нотолгоо #1 - Амжилтын нотолгоо #n					-Өгөөжтэй үр дүн #1 -Өгөөжтэй үр дүн #n							
Үнэлгээ	Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн	Үнэлгээ	Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн	Үнэлгээ	Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн
Засаглалын үүрэг, үйл ажиллагаа хэрэгжсэн эсэх?						Амжилтын нотолгоо бий эсэх?						Өгөөжтэй үр дүнд хүрсэн эсэх?					
 МТ-ийн төлөвшлийн засаглал сайжирна																	

4-р зураг. МТ-ийн засаглалын үнэлгээний бүтэц

Хэмжилтийн загварыг дараах шалтгааны улмаас ангилал тус бүрийн үзүүлэлтэд бус МТ-ийн үзүүлэлтийн засаглалын ерөнхий ангилалд хэрэглэнэ.

- ангилал доторх үзүүлэлт бүрийг үнэлэх нь ангилал тус бүрийн хувьд нэгтгэх нэмэлт дүрмийг шаардаж, төвөгтэй байдлыг бий болгодог,
- өөр өөр үзүүлэлтүүдийг бусдаас нь илүү чухалчилж болох бөгөөд энэ тэдгээрийг үнэлж цэгнэх схемийг бий болгох нарийн төвөгтэй байдлыг шаарддаг;
- МТ-ийн үзүүлэлтийн засаглалын түвшинд үнэлгээ хийх нь чанарын үнэлгээний аргын хувьд илүү нарийвчлалыг бий болгохгүй бөгөөд нэмэлт ажил шаардана. Энэ нь “хэтрүүлэг”-д хүргэж болзошгүй.

4-р зурагт МТ-ийн үзүүлэлтийн засаглал ба МТ-ийн засаглалын төлөвшлийн сайжралтын хамаарлыг сумаар харуулсан болно. Үүнийг дараах байдлаар товч дүгнэж болно.


- МТ-ийн албан ёсны засаглал байхгүй тохиолдолд тухайн байгууллага нь МТ-ийн төлөвшлийн засаглалын түвшин доогуур байх магадлалтай;
- төлөвшлийн түвшинг дээшлүүлэхийн тулд эрх бүхий субъект нь МТ-ийн үүрэг, үйл ажиллагааны зохих засаглалыг өөр дээрээ авч болног;
- Ингэснээр байгууллага дахь МТ-ийн нэвтрүүлэлт, ашиглалт сайжирч, амжилтын нотолгоог бий болгоно;
- энэ нь эргээд тухайн байгууллага өгөөжтэй үр дүнд хүрэхийг дэмжиж, идэвхжүүлнэ.

Эдгээр үзэл баримтлалыг 6.4-т дурдсан МТ-ийн төлөвшлийн загварт улам өргөжүүлсэн болно.

6.3 МТ-ийн засаглалын үнэлгээ

МТ-ийн засаглалын үнэлгээг нь МТ-ийн засаглалын жишиг загварын хамрах хүрээн дэх бүх чиглэлд үзүүлэлтүүдийн ангилал бүрийг үнэлэх замаар гүйцэтгэнэ.

5-р зурагт МТ-ийн үйл ажиллагаанд хамаарах засаглалын үнэлгээний бүх жишээг график дүрслэлээр үзүүлэв. Үүнийг 7.3-т дурдсан дэлгэрэнгүй тайлангийн хамт үзэх шаардлагатай.



Түлхүүр

- | | | | |
|---|-------------------|---|------------------------|
| 1 | Засаглалын үүрэг | Х | Үйл ажиллагааны чиглэл |
| 2 | Амжилтын нотлогоо | Ү | Үнэлгээ |
| 3 | Өгөөжтэй үр дүн | | |

5-р зураг – МТ-ийн засаглалын үнэлгээний график дүрслэлийн жишээ

6.4 МТ-ийн төлөвшлийн загварын засаглал

МТ-ийн төлөвшлийн загварын засаглал нь МТ-ийн гол үзүүлэлтүүдийн засаглалын хүрээнд байгууллагын чадавхи илүү өндөр түвшинд хүрч нэмэгдсэнтэй холбоотой.

Ерөнхий агуулга нь засаглалын ажил үүргийг анх гүйцэтгэхээс, амжилтын нотолгоог олж харж, эцэст нь байгууллагад өгөөжтэй үр дүнд хүрэх хүртэл өөрчлөгддөг. Ийнхүү өсөн нэмэгдэж буй чадавхийг МТ-ийн үйл ажиллагааны засаглалын бүх хүрээнд харуулах шаардлагатай.

Байгууллагын МТ-ийн төлөвшлийн түвшний засаглал нь МТ-ийн жишиг загварын засаглалын бүх үйл ажиллагааны чиглэлд хамаарах үзүүлэлтийн ангилал тус бүрийн үнэлгээнд үндэслэсэн бөгөөд 6.2.3-т дурдсан хэмжилтийн загварын дагуу тодорхойлсон болно.

Төлөвшлийн түвшин бүр МТ-ийн үзүүлэлтийн засаглалын ангилал тус бүрд байгууллагын хүрэх ёстой хамгийн бага шатлалыг үйл ажиллагааны бүх чиглэлээр тодорхойлно. Жишээ нь , 2-р түвшний шатлалд хүрэхийн тулд үйл ажиллагааны бүх

чиглэлд засаглалын үүрэг (EDM)-ийг "нэлээд хэрэгжүүлэх" шаардлагатай бөгөөд амжилтын нотолгоо болон өгөөжтэй үр дүн "зарим байдлаар хэрэгжсэн" байх шаардлагатай.

MT-ийн төлөвшлийн түвшний засаглалыг 10-р хүснэгтийн дагуу тодорхойлно.

10-р хүснэгт – MT-ийн төлөвшлийн түвшний засаглал

Үзүүлэлтүүд				
Засаглалын үүрэг / (EDM)	Амжилтын нотолгоо	Өгөөжтэй үр дүн		
Мэдэхгүй эсхүл хэрэгжээгүй	Мэдэхгүй эсхүл хэрэгжээгүй	Мэдэхгүй эсхүл хэрэгжээгүй	<ul style="list-style-type: none"> - MT-ийн засаглалын талаар ямар ч манлайлал, үүрэг амлалт байхгүй - Эрх бүхий субъект, гүйцэтгэх менежерүүд MT-ийг засаглахад ашиглаж болох механизмуудыг мэдэхгүй - MT-ийн дотоод хяналт дутмаг - Байгууллага MT-ийн холбоотой эрсдэлийн талаар огт мэддэггүй 	Засаглалгүй (0 түвшин)
Бага зэрэг хэрэгжсэн	Мэдэхгүй эсхүл хэрэгжээгүй	Мэдэхгүй эсхүл хэрэгжээгүй	<ul style="list-style-type: none"> - Эрх бүхий субъект, гүйцэтгэх менежерүүд MT-ийн засаглалын зорилго, зорилтын талаар мэддэг - MT-ийн засаглалын суурь механизм хэрэгжиж эхэлсэн - Зарим дотоод хяналт эхэлсэн - Байгууллага MT-ийн холбоотой эрсдэлийн талаар мэддэг 	Засаглалын эхлэл (1 түвшин)
Нэлээд хэрэгжсэн	Бага зэрэг хэрэгжсэн	Бага зэрэг хэрэгжсэн	<ul style="list-style-type: none"> - Эрх бүхий субъект болон гүйцэтгэх менежерүүд MT-ийн засаглалд тууштай хандаж байгаагаа харуулж эхэлж байгаа. - Гол оролцогч талуудыг тодорхойлж, татан оролцуулсан - Байгууллага даяар MT-ийн механизмын засаглалыг өргөн хүрээнд хэрэгжүүлж байгаа - Байгууллага даяар MT-ийн дотоод хяналтыг өргөн хүрээнд хэрэгжүүлж байгаа - Байгууллага MT-ийн эрсдэлийг удирдаж эхэлсэн - MT-ийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтаас үр өгөөж хүртэж эхэлж байна 	Засаглалыг хэрэгжүүлж байна (2 түвшин)

Бүрэн хэрэгжсэн	Нэлээд хэрэгжсэн	Бага зэрэг Хэрэгжсэн	<ul style="list-style-type: none"> - Эрх бүхий субъект МТ-ийн засаглалыг дэмжигч орчинг бий болгосон, үүнд удирдлагын үүрэг хариуцлага, мэдлэг ойлголт, боловсрол, сонирхогч талуудын оролцоо зэрэг орно. - Бодлого, бүтэц, үйл явцыг багтаасан мэдээллийн технологийн тогтолцоог бий болгосон - Байгууллагын менежментийн тогтолцооны нэг хэсэг болох МТ-ийн дотоод хяналтын тогтолцоо бий болсон - Байгууллага МТ-ийн засаглалыг сайжруулах боломжуудыг тодорхойлдог - Байгууллага нь МТ-ийн эрсдэлийг удирдаж байгаа эсэхээ баталгаажуулдаг - МТ-д оруулсан хөрөнгө оруулалтаас үр ашиг тогтмол хүртдэг 	Засаглал бий болсон (3 түвшин)
Бүрэн хэрэгжсэн	Бүрэн хэрэгжсэн	Нэлээд хэрэгжсэн	<ul style="list-style-type: none"> - МТ-ийн засаглалыг дэмжигч тогтвортой орчинг бүрдүүлсэн. Энэ нь эрх бүхий субъект болон гүйцэтгэх менежерүүдээс эхлээд зан төлвийн өөрчлөлтийг бий болгосон. - МТ-ийн засаглалын тогтолцоо, үүнд дүрэм, үүрэг, хариуцлага, засаглалын удирдах бүлэг, эрх бүхий субъектын нөөц эрх мэдэл сайжирсан. - МТ-ийн дотоод хяналтын систем нь Хариуцлага, Стратеги, Худалдан авалт, Гүйцэтгэл, Нийцэл, Хүний зан төлөв зэрэг МТ-ийн засаглалыг дэмжих зорилгоор сайжирсан. - Байгууллагын МТ-ийн засаглалын сайжруулалтыг баталгаажуулахын тулд байнгын дүн шинжилгээ хийдэг - Байгууллага нь МТ-ийн засаглалын эрсдэлийг удирдаж, МТ-ийн хөрөнгө оруулалт нь бизнесийн үнэ цэнийг бий болгодог. 	Засаглалд хүрсэн (4 түвшин)
Бүрэн хэрэгжсэн	Бүрэн хэрэгжсэн	Бүрэн хэрэгжсэн	<ul style="list-style-type: none"> - МТ-ийн засаглалын дэмжигч орчныг оновчтой болгож, байгууллагын хэмжээнд зан үйл, соёлын өөрчлөлтийг бий болгосон - МТ-ийн тогтолцооны засаглалыг байгууллагын болон гадаад шаардлагад нийцүүлэн оновчтой болгосон - МТ-ийн дотоод хяналтын системийг байгууллагын болон гадаад шаардлагад нийцүүлэн оновчтой болгосон - Байгууллага нь бүх сонирхогч талуудаас олж авсан санал хүсэлт, байнгын хяналтаас МТ-ийг сайжруулах боломжийг байнга ашигладаг. - Байнгын дүн шинжилгээг оновчтой болгосон. <p>Байгууллага дахь МТ-ийн засаглалыг сайжруулахын тулд бүх оролцогч талуудаас санал хүсэлт авах эргэх холбоотой.</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллага нь МТ-ийн эрсдэлийг удирдаж, МТ-ийн шинэчлэл нь бизнесийн өөрчлөлтийг удирддаг. 	Оновчтой засаглал (5 түвшин)

7 Үнэлгээний үйл ажиллагаа

7.1 Үнэлгээг төлөвлөх

Үнэлгээний ажилтан үнэлгээний төлөвлөгөөг боловсруулж, баримтжуулж, санхүүжүүлэгч хянан баталгаажуулна. Төлөвлөгөө нь дор хаяж дараахь зүйлийг агуулсан байна.

- санхүүжүүлэгч ба санхүүжүүлэгчийн байгууллагатай хамаарал (5.1, 5.3.3-ыг үзнэ үү);
- үнэлгээний зорилго (5.1, 5.2-ыг үзнэ үү);
- үнэлгээний хамрах хүрээ (5.1-ийг үзнэ үү);
- үнэлгээний төрөл (5.2-ыг үзнэ үү);
- үйл ажиллагааны чиглэл, үнэлгээний үзүүлэлтийн онцлог(6.2.1, 6.2.3-ыг үзнэ үү);
- үнэлгээний хугацаа (5.2-ыг үзнэ үү);
- Үнэлгээний явцад гүйцэтгэх үйл ажиллагаа (5.2, 7.2-ыг үзнэ үү);
- Үнэлгээнд оролцогчдын үүрэг, хариуцлага (5.3-ыг үзнэ үү);
- Үнэлгээг хийхэд шаардлагатай нөөц (5.3-ыг үзнэ үү);
- үнэлгээний төсөв (5.2-ыг үзнэ үү);
- төлөвлөсөн үнэлгээний тайлангийн тодорхойлолт (7.3-ыг үзнэ үү).

А хавсралтад МТ-ийн технологийн засаглалын үнэлгээг хийхэд байгууллагуудад туслах үнэлгээний бүтцийн жишээг оруулсан болно. Байгууллага бүр өөрийн ирээдүйн засаглалын төлөвөө тодорхойлсон хэмжээнд үндэслэн ангилал тус бүрийн үзүүлэлтүүдийг өөрчлөх, нэмэх, хасах замаар үйл ажиллагааны чиглэлээ өөрчилнө.

Үнэлгээний үүрэг, хариуцлагыг үнэлгээнд оролцох ажилтнуудад хуваарилж, мэдэгдэнэ.

7.2 Үнэлгээг хийх

7.2.1 Мэдээлэл цуглуулах

МТ-ийн засаглалыг үнэлэхэд шаардагдах өгөгдөл нь үнэлгээний төлөвлөгөөнд дэлгэрэнгүй тусгасны дагуу үнэлгээний хамрах хүрээнд хангалттай байх ёстой.

Дээр байдлаар тодорхойлсон өгөгдлийг дараах шаардлагуудыг харгалзан, системчилсэн байдлаар цуглуулна.

- шатлалыг шалгах үндэслэл болох бодит нотлох баримтыг олж, цуглуулсан байх;
- байгууллагын эрх бүхий субъект, гүйцэтгэх менежерүүд, МТ-ийн мэргэжилтнүүдэд тавих асуултын жагсаалтыг багтаасан субьектив нотлох баримтыг цуглуулах аргуудыг боловсруулсан байх;
- объектив ба субьектив нотлох баримтыг тухайн үнэлгээний зорилго, хамрах хүрээ, төрлийг хангахад хангалттай эсэхийг үнэлнэ.

7.2.2 Үнэлгээ хийх

Үнэлгээний үйл явц нь үнэлгээний төлөвлөгөөнд тусгасан МТ-ийн үйл ажиллагааны хүрээ, үнэлж буй үзүүлэлтүүд зэргээс хамаарч өөр өөр байж болно.

Дараахь нийтлэг үйл ажиллагааг дагаж мөрдөнө.

- МТ-ийн үйл ажиллагааны хүрээний засаглалын үзүүлэлтийг хэмжилтийн загварын дагуу үнэлэх (6.2.3-ыг үзнэ үү);

- засаглалын үйл ажиллагааны хүрээ, үнэлэгдэж буй үзүүлэлтүүд, цуглуулсан мэдээллийн хоорондын хамаарлыг бүртгэх (7.2.1-ийг үзнэ үү);
- төлөвшлийн түвшинг тодорхойлох (6.4-ийг үзнэ үү);
- төлөвшлийн үнэлгээний түвшинд дүн шинжилгээ хийж, сайжруулах (6.4-ийг үзнэ үү) зорилгоор төлөвшил хангалтгүй байгаа үндсэн шалтгааныг тодруулах,
- сайжруулалтын жагсаалтыг гаргаж, баримтжуулах (7.3-ыг үзнэ үү).

7.3 Үнэлгээг тайлагнах

Үнэлгээний ажилтан үнэлгээний гол илэрц (findings)-үүдийг агуулсан албан ёсны тайланг гаргана. Түүнчлэн, холбогдох дагалдах баримт бичгийг бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд бэлэн байвал зохино. Илэрсэн гол сул тал, эрсдэлийг арилгах сайжруулах төлөвлөгөөг тайланд тусгана. Үнэлгээний албан ёсны тайланг санхүүжүүлэгч болон эрх ашиг нь хөндөгдөж буй талуудтай үр дүнтэй харилцах боломжтой байдлаар баримтжуулж, үнэлгээний санхүүжүүлэгчид өгөх бөгөөд эрх бүхий субъектээр батлагдсан байна. Тайлан нь дараахь гол зүйлийг агуулна.

- үнэлгээний огноо, үргэлжлэх хугацаа;
- үнэлгээний ажилтны нэр, үүрэг;
- үнэлгээнд оролцогчид (нэр, үүрэг, үйл ажиллагааны чиглэлээр);
- үнэлгээний хамрах хүрээ;
- батлагдсан үнэлгээний төрөл;
- үнэлгээ ба төлөвшлийн загвар;
- Байгууллага дахь МТ-ийн засаглалын үнэлгээний үр дүн;
- сайжруулах, эрсдэлийг бууруулах үзүүлэлтүүд.

А хавсралт (Мэдээллийн)

Үнэлгээний бүтэц — МТ-ийн үйл ажиллагааны чиглэлийн засаглал

Энэхүү хавсралтад МТ-ийн жишиг загварын засаглалын үйл ажиллагааны долоон чиглэлд зориулсан үнэлгээний бүтцийн жишээг өгсөн болно. Энэ нь ISO/IEC 38500, ISO/IEC TS 38501, ISO/IEC TR 38502 стандарт дах ангиллын дагуу МТ-ийн үзүүлэлтүүдийн засаглалын жишээг агуулсан бөгөөд энэ нь зөвхөн мэдээллийн зорилготой.

Үнэлгээний ажилтнууд байгууллагын МТ-ийн үзүүлэлтүүдийг засаглалын онцлогийг ойлгохын тулд эрх бүхий субъект болон дээд удирдлагатай хамтран ажиллаж, улмаар энэ хавсралтын агуулгыг байгууллагын нөхцөл байдалд тохируулан өөрчилнө.

Үзүүлэлтүүд нь чанарын болон тоон шинжтэй бөгөөд тодорхой, хамааралтай, бодитой хүрч болохуйц, хэмжигдэхүйц байвал зохино.

А.1 хүснэгт – Дэмжигч механизмууд

Засаглалын үүрэг ба үйл ажиллагаа (EDM)						Амжилтын нотолгоо						Өгөөжтэй үр дүн					
<p>- Эрх бүхий субъект нь холбогдох механизмуудад хяналт тавьдаг МТ-ийн засаглалыг бий болгосон.</p> <p>- Эрх бүхий субъект нь байгууллагын доторх МТ-ийн засаглалын тогтолцооны нийцэлийг тогтмол үнэлдэг.</p>						<p>- Засаглалын тогтолцоог бий болгосон, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - стратеги, бодлого, шийдвэр гаргах бүтэц, ажлын даалгавар, дүрэм журам гэх мэт. <p>- Засаглалын удирдах хэсэг байгуулагдсан, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - баримт бичгийн удирдлага, өөрчлөлтийн хөтөлбөрийн удирдлага гэх мэт. <p>- Эрх бүхий субъект нь МТ-ийн гол шийдвэр гаргахдаа дотоод болон гадаад шаардлагыг харгалзан үздэг, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> — бизнесийн зорилго, стратеги, эрсдлийг бууруулах эрмэлзэл, байгууллагын соёл гэх мэт; - зохицуулалтын орчин, технологийн дэвшил, насны /generational /хандлага гэх мэт. <p>- МТ-ийн засаглалыг удирдахаар томилогдсон бизнесийн сангхүүжүүлэгч</p> <p>- Оролцогч талуудыг зохих ёсоор удирддаг, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - оролцогч талуудаа тодорхойлсон; оролцогч талууд нь өөрсдийн зорилго, үүрэг, хариуцлагаа мэддэг; - мониторинг зэрэг байнгын сайжруулалтыг хэрэгжүүлдэг. <p>Эрх бүхий субъект нь байгууллагын МТ-ийн үнэ цэнийн талаар мэддэг; бизнесийг дэмжих, МТ-ийн дэмжлэгийг удирдлагын зүгээс үнэлдэг; гэх мэт.</p>						<p>- МТ-ийн засаглал нь холбогдох асуудлуудад анхаарч, үр дүнтэй удирддаг.</p> <p>- МТ-ийн засаглал нь идэвхитэй манлайлалтай.</p> <p>- Оролцогч талууд байгууллагын мэдээллийн технологийн засаглалд бүрэн дүүрэн оролцдог бөгөөд байгууллагын МТ засаглалд идэвхитэй хувь нэмэр оруулдаг.</p> <p>- МТ-ийн засаглал нь тасралтгүй сайжирч байгаа</p>					
Үнэлгээ						Үнэлгээ						Үнэлгээ					
	Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн
Засаглалын үүрэг, үйл ажиллагаа хэрэгжсэн эсэх?						Амжилтын нотолгоо бий эсэх?						Өгөөжтэй үр дүнд хүрсэн эсэх?					

A.2 хүснэгт – Хариуцлага

Засаглалын үүрэг ба үйл ажиллагаа (EDM)						Амжилтын нотолгоо					Өгөөжтэй үр дүн						
<p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн хариуцлагаа төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхийг удирдан чиглүүлвэл зохино.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн засаглал дах ажилтны хариуцлагын гүйцэтгэлд мониторинг хийдэг (жишээ нь, удирдах хороонд эсхүл удирдах хороонд санал оруулдаг хүмүүст)</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн ашиглалт нь зорилгодоо хүрч буй эсэхийг ажигладаг.</p> <p>— Эрх бүхий субъект нь байгууллагын МТ-ийн одоогийн болон ирээдүйн ашиглалттай холбоотой үүрэг хариуцлагыг хуваарилах хувилбаруудыг үнэлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн талаар шийдвэр гаргах үүрэг хүлээсэн хүмүүсийн ур чадварыг үнэлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь байгууллагын бизнесийн хэрэгцээг дэмждэг хангамжийн зохицуулалтыг (дотоод болон гадаад нийлүүлэлт) удирдан чиглүүлдэг</p>						<p>— Гүйцэтгэх менежерүүд МТ-ийн шийдлүүдийг хэрэгжүүлэхдээ бизнесийн үйл явц, байгууллагын бүтэц, хүний өөрчлөлтийг удирдан чиглүүлдэг.</p> <p>— Гүйцэтгэх менежерүүд МТ-ийг бууруулбал зохих зардал гэж бус харин өгөөжөө өгөх хөрөнгө оруулалт гэж үздэг.</p> <p>— Гүйцэтгэх менежерүүд дараахь зүйлсийг харгалзан МТ-ийн хамгийн сайн загварыг тодорхойлдог:</p> <ul style="list-style-type: none"> — шийдвэр гаргах эрх ба хяналтын бүтэц (төвлөрсөн, төвлөрсөн бус, тухайлсан гэх мэт); — нийлүүлэлт: МТ-ийн хангамжийг оновчтой болгох (гаднаас гүйцэтгүүлэх стратеги); <p>— МТ-ийн хангамж, ашиглалтын үүрэг хариуцлагатай холбоотой гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг эрх бүхий субъектэд тайлагнадаг.</p>					<p>— Байгууллага нь МТ-ийн тусламжтайгаар бизнесийн өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлж байна.</p> <p>— МТ байгууллагын үнэ цэнийг бий болгодог.</p> <p>— Байгууллага нь шаардлагатай чанартай үйлчилгээгээ хамгийн үр дүнтэй, үр өгөөжтэй байдлаар хүлээн авдаг.</p>						
Үнэлгээ						Үнэлгээ					Үнэлгээ						
	Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн
Засаглалын үүрэг, үйл ажиллагаа хэрэгжсэн эсэх?						Амжилтын нотолгоо бий эсэх?					Өгөөжтэй үр дүнд хүрсэн эсэх?						

А.3 хүснэгт – Стратеги

Засаглалын үүрэг ба үйл ажиллагаа (EDM)						Амжилтын нотолгоо						Өгөөжтэй үр дүн					
<p>— Эрх бүхий субъект төлөвлөгөө, бодлогыг авч үзэхдээ эдгээр нь байгууллагын зорилгод нийцэж, гол оролцогч талуудын хууль ёсны шаардлагыг хангахын тулд МТ-ийн ашиглалт болон МТ-ийн үйл ажиллагааг үнэлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь бизнесийн зорилгыг дэмжихэд МТ ашиглах талаар үр дүнтэй, цаг алдалгүй шийдвэр гаргах хувилбаруудыг үнэлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн хөгжлийн үр шимийг хүртэх стратеги, бодлогыг бэлтгэх, ашиглах ажлыг удирдан чиглүүлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ бизнесийг хэрхэн дэмжиж байгааг ажигладаг.</p>						<p>— Байгууллагын стратеги, зорилт, нөөцийн болон цаг хугацааны шаардлагад нийцсэн МТ-ийн стратеги болон төлөвлөгөөг баталсан.</p> <p>— Байгууллагын стратегийн зорилттой нийцсэн МТ-ийн бодлогыг баталсан.</p> <p>— Шийдвэр гаргахад хэрэглэх өгөгдлийг ашиглах боломж, нууцлал, бүрэн бүтэн байдал, нэгдмэл байдал, хүртээмжтэй холбоотой бизнесийн шаардлагыг тодорхойлж, хэрэгжүүлж байна.</p>						<p>— МТ нь байгууллагын үйл ажиллагааг идэвхитэй дэмждэг, стратегийн өөрчлөлтийг МТ-ийн тусламжтайгаар зохих ёсоор хэрэгжүүлдэг.</p> <p>— Байгууллагын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх систем нь өндөр чанартай, цаг алдалгүй мэдээллээр хангадаг.</p> <p>— Байгууллагын зорилго нь МТ-ийн шинэчлэлээр хэрэгждэг.</p>					
Үнэлгээ						Үнэлгээ						Үнэлгээ					
	Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн
Засаглалын үүрэг, үйл ажиллагаа хэрэгжсэн эсэх?						Амжилтын нотолгоо бий эсэх?						Өгөөжтэй үр дүнд хүрсэн эсэх?					

A.4 хүснэгт – Худалдан авалт

Засаглалын үүрэг ба үйл ажиллагаа (EDM)						Амжилтын нотолгоо					Өгөөжтэй үр дүн						
<p>— Эрх бүхий субъект нь дэмжигдсэн саналуудын эрсдэл болон хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өртгийн тэнцвэрийг хангахын тулд МТ-ийн ашиглалтын хувилбаруудыг үнэлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь бизнесийн зорилгод ач холбогдлын эрэмбийн дагуу нөөц, төсвийг хуваарилсан эсэхийг хянадаг.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн хөрөнгийг (систем ба дэд бүтэц) зохих баримт бичгийг бэлтгэж, журмын дагуу худалдан авах талаар удирдан чиглүүлж, шаардлагатай нөөцөөр хангах боломж бүрдүүлдэг.</p> <p>— МТ-ийн аливаа худалдан авалт хийхдээ байгууллага болон ханган нийлүүлэгчид байгууллагын зорилгын талаарх нийтлэг ойлголтыг хадгалж буй эсэхийг эрх бүхий субъект нь ажиглаж, хяналт тавьдаг.</p> <p>— Эрх бүхий субъект нь тэргүүлэх чиглэл, төсвийн хязгаарлалтын хүрээнд байгууллагын МТ-ийн хэрэгцээг хангахуйц нөөцийг хуваарилдаг.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн дэмжигдсэн санал нь хуваарилагдсан нөөцөөр шаардлагатай хугацаанд зорилгодоо хүрч байгааг эсэх явцыг ажиглаж хянадаг.</p> <p>— МТ-ийн хөрөнгө оруулалт нь шаардлагатай чадавхиар хангаж буй эсэхийг эрх бүхий субъект ажиглаж хянадаг.</p>						<p>— МТ-ийн хөрөнгө оруулалтууд нь саад тотгорыг даван туулж хөрөнгө оруулалтын өгөөжөө өгөхийн тулд багцын бүтэцтэй.</p> <p>— МТ-ийн худалдан авалтын үйл явцын шийдлүүд нь дараах шаардлагуудад нийцсэн байдаг: бизнесийн тохиолдол, эрсдэл, функциональ байдал, ашиглах боломж, архитектур, аюулгүй байдал, гүйцэтгэл, хүртээмж гэх мэт.</p> <p>— Өөрчлөлтийн хөтөлбөр нь зардал, эрсдэл, хуваарь, хүний өөрчлөлт, үр өгөөжийг сайтар удирдаж бизнесийн боломжийг бүрдүүлэхээр зохион байгуулагдсан.</p> <p>— МТ-ийн худалдан авалттай холбоотой гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг эрх бүхий субъектэд тайлагнадаг.</p>					<p>— МТ-ийн хөрөнгө оруулалтыг бизнест оруулсан ихээхэн хувь нэмэр нь хэр сонирхолтой, хүрэх боломжтой гэдгээр эрэмбэлдэг</p> <p>— МТ-ийн г сонгосон шийдлүүд нь Бизнесийн шаардлагуудыг дэмждэг.</p> <p>— Хөтөлбөрүүд төлөвлөгөөний дагуу хэрэгждэг бөгөөд бизнесийн үр өгөөжтэй.</p>						
Үнэлгээ						Үнэлгээ					Үнэлгээ						
	Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн
Засаглалын үүрэг, үйл ажиллагаа хэрэгжсэн эсэх?						Амжилтын нотолгоо бий эсэх?					Өгөөжтэй үр дүнд хүрсэн эсэх?						

А.5 хүснэгт – Гүйцэтгэл

Засаглалын үүрэг ба үйл ажиллагаа (EDM)						Амжилтын нотолгоо					Өгөөжтэй үр дүн						
<p>— Эрх бүхий субъект нь бизнесийн үйл явцыг МТ нь шаардлагатай чадавхи, нөөцөөр дэмжих боломжийг бүрдүүлэхийн тулд менежерүүдийн санал болгож буй төлөвлөгөөг үнэлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь байгууллагын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх, МТ-ийн ашиглалттай холбоотой эрсдлийг залруулахад чиглэсэн саналыг үнэлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн үйл ажиллагаанаас цаашид бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг үнэлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь мэдээллийн нэгдмэл байдал, МТ-ийн өмч, түүнчлэн холбогдох оюуны өмч, байгууллагын ой санамжийг хамгаалахтай холбоотой эрсдэлийг үнэлдэг.</p>						<p>— МТ нь өндөр эрэлт болон/эсвэл гамшгийн үед ч зохих хариу үйлдэл үзүүлэх боломжтой.</p> <p>— МТ-ийн өөрчлөлт, шинэчлэлтийг зөвхөн бизнест төлөвлөсөн тасалдлын үед зохих ёсоор төлөвлөж, үнэлж хэрэгжүүлдэг.</p> <p>— МТ нь өгөгдөлд зөвшөөрөлгүй хандалт эсхүл өөрчлөлтөөс хамгаалсан үр дүнтэй бодлого, дүрэм журам, технологийг бий болгосон . Өгөгдлийн нэгдмэл байдалд хяналт тавьдаг.</p> <p>— Хүсэлт, осол гэмтэл, асуудлыг шийдэж, үйлчлүүлэгчдэд тодорхой түвшинд үйлчилгээ үзүүлэх идэвхтэй үйлчилгээний цэг бич болсон.</p>					<p>— Бүх оролцогч талууд тэдний шаардлагад нийцсэн үйлчилгээний түвшин, үйлчилгээний чанарыг хангадаг МТ-ийн системүүдтэй харилцах, гүйлгээ хийх боломжтой.</p> <p>— Мэдээлэл нь бүрэн, үнэн зөв, найдвартай, хүртээмжтэй бөгөөд алдах, буруугаар ашиглахаас хамгаалагдсан.</p> <p>— МТ-ийн дэмжлэг авах тухай оролцогч талуудын хүсэлтэд идэвхтэй тусалдаг.</p>						
Үнэлгээ						Үнэлгээ					Үнэлгээ						
	Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн
Засаглалын үүрэг, үйл ажиллагаа хэрэгжсэн эсэх?						Амжилтын нотолгоо бий эсэх?					Өгөөжтэй үр дүнд хүрсэн эсэх?						

А.6 хүснэгт – Нийцэл

Засаглалын үүрэг ба үйл ажиллагаа (EDM)						Амжилтын нотолгоо						Өгөөжтэй үр дүн					
<p>— Эрх бүхий субъект нь тухайн байгууллагад МТ-ийн ашиглалтад биелүүлэх дотоод үүргийн талаар бодлого бий болгож, мөрдүүлэх талаар удирдан чиглүүлнэ.</p> <p>— Эрх бүхий субъект нь бодлого хэрхэн мөрдөж байгаад ажиглалт хяналт хийнэ.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн үйл ажиллагаанд ажиглалт хяналт (monitoring) хийнэ. Жишээ нь. хөрөнгө, өгөгдлийг устгахад холбогдох үүргээ биелүүлэх зорилгоор</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн ашиглалтыг зохих эрсдэлийн удирдлагаар хангана.</p> <p>— МТ нь үүрэг (зохицуулалт, хууль тогтоомж, гэрээ), дотоод бодлого, стандарт, мэргэжлийн шаардлагад хэр нийцэж байгааг эрх бүхий субъект тогтмол үнэлнэ.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн ашиглалт нь холбогдох үүрэг хариуцлага, дотоод бодлого, стандарт, удирдамжид нийцүүлэхийн тулд зохицуулах механизмыг бий болгохыг асуудлыг хариуцсан хүмүүсийг удирдан чиглүүлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-той холбоотой бүх үйлдэл нь ёс зүйтэй байхыг удирдан чиглүүлдэг.</p> <p>— Эрх бүхий субъект нь тохиромжтой тайлагнах, аудитын ажиллагаагаар дамжуулан байгууллагад тохирсон, иж бүрэн дүн шинжилгээг цаг тухайд нь хийж, МТ-ийн нийцэлд ажиглалт хяналт хийнэ.</p>						<p>— МТ-ийн хангамж, ашиглалтын талаар байгуулалтын зохистой зан төлөвийг төлөвшүүлэхийн тулд тогтмол хянаж байдаг холбогдох бодлого бий болно.</p> <p>— Бүх ажилтнуудад байгууллагын бодлого, журмын талаар зохих мэдлэг ойлголт, сургалтыг хүргэхийн тулд мөшгөх тогтолцоог бий болсон байна.</p> <p>— Байгууллагын бодлого, үйлчилгээний шаардлага, эрсдлийг бууруулах эрмэлзэлд нийцсэн МТ-ийн менежментийн тогтолцоо, үйл явц, хяналтыг бий болгосон.</p> <p>— Бизнесийн тасралтгүй байдал, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хамарсан эрсдэлийн удирдлагын гол систем, хяналтыг тогтмол туршдаг байна.</p> <p>— Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, шаардлагатай МТ-ийн бодлого, үйл явц, хяналтыг хэрэгжүүлэн, түүнчлэн бие даасан баталгаагаар хангадаг.</p> <p>— Байгууллагын үндсэн хяналтыг хангахтай холбоотой гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг эрх бүхий субъектэд тайлагнадаг.</p>						<p>— Байгууллага бодлого, дүрэм журмаа мөрддөг нь МТ-т зохих ёсоор хэрэгждэг.</p> <p>— Байгууллага өөрийн мэдээлэл, гүйлгээгээ зөв удирддаг тул хууль эрх зүйн болон/эсвэл зохицуулалтын шаардлагын зөрчил үүсдэггүй.</p>					
Үнэлгээ						Үнэлгээ						Үнэлгээ					
	Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн
Засаглалын үүрэг, үйл ажиллагаа хэрэгжсэн эсэх?						Амжилтын нотолгоо бий эсэх?						Өгөөжтэй үр дүнд хүрсэн эсэх?					

A.7 хүснэгт – Хүний зан төлөв

Засаглалын үүрэг ба үйл ажиллагаа (EDM)						Амжилтын нотолгоо						Өгөөжтэй үр дүн					
<p>— Эрх бүхий субъект нь хүний зан төлвийг тодорхойлж, зохих байдлаар анхаарахын тулд МТ-ийн үйл ажиллагааг үнэлнэ.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн үйл ажиллагаа хүний тодорхойлсон зан төлөвт нийцэх талаар удирдан чиглүүлнэ.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн ажилтнууд мэргэжлийн зан төлөв, хөгжлийн талаархи холбогдох удирдамжийг мөрдөхийг удирдан чиглүүлнэ.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ үйл ажиллагаа хүний тодорхойлогдсон зан төлөвт хамааралтай хэвээр эсэх, үүнд зохих анхаарал хандуулж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд ажиглалт хяналт тавьдаг.</p> <p>— Эрсдэл, боломж, асуудал, болгоомжлох асуудлуудыг хэн ч, хэзээ ч тодорхойлж, мэдэгдэх боломжтой байхыг эрх бүхий субъект удирдан чиглүүлнэ.</p> <p>— Эрх бүхий субъект нь МТ-ийн зохистой ашиглалтад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд ажлын практик дадалд ажиглалт хяналт хийнэ.</p>						<p>— Гүйцэтгэх менежерүүд нь зохих бодлогын боловсрол, сургалт, болон ийцлийн ажиглалт хяналтын дэмжлэгтэйгээр хэрэглэгчид болон үйлчилгээ үзүүлэгчдийг манлайллаар хангана.</p> <p>— Байгууллагын МТ-ийн ашиглалтын бүхий чиглэлд бүх хэрэглэгчдэд зориулсан тасралтгүй боловсрол, сургалт, ур чадварын шалгалт бий болсон.</p> <p>— Хүний зан төлөвтэй холбоотой МТ-ийн эрсдлийг тодорхойлж, мөшгөж, зохих ёсоор удирдана.</p> <p>— Хүний зан төлөвтэй холбоотой гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг эрх бүхий субъектэд мэдээлнэ.</p>						<p>— Оролцогч талууд байгууллагын МТ-ийг зохистой ашигладаг.</p> <p>— Ажилтнууд МТ-ийг бүтээмжтэй, үр дүнтэй ашигласнаар бизнесийн үр ашиг, үнэ цэнэ бий болсон.</p>					
Үнэлгээ						Үнэлгээ						Үнэлгээ					
	Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн		Мэдэхгүй	Үгүй	Бага зэрэг	Нэлээд	Бүрэн
Засаглалын үүрэг, үйл ажиллагаа хэрэгжсэн эсэх?						Амжилтын нотолгоо бий эсэх?						Өгөөжтэй үр дүнд хүрсэн эсэх?					